

1 Нийгмийн сүлжээн дэх үзэн ядалтын эсрэг дүрмүүд – цахим орчинд хууль хэрэгжүүлэлтийг сайжруулах

Нийгмийн сүлжээнд хууль хэрэгжүүлэлтийг сайжруулах (Цахим орчинд хууль хэрэгжүүлэх тухай хууль – СүлжээХХ) тухай хууль/2017 оны 10 сарын 1 өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хуулийн зорилго нь үзэн ядалтын гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх, худал мэдээ түгээлт болон бусад контенттэй нийгмийн сүлжээний талбарт илүү үр дүнтэй тэмцэхэд оршино. Үүнд жишээ нь гутаан доромжлох, цуу тараах, гүтгэх, олон нийтийг гэмт хэрэгт уриалах, яс үндэстэнг дайсагнуулах, хүчирхийллийг сурталчлах, заналхийлэх үйлдлүүд багтана. Хэрэглэгчдийн гомдлуудыг, ялангуяа үзэн ядалтын гэмт хэрэг, бусад эрүүгийн хариуцлага хүлээлгэх контентийн тухай санал хүсэлтүүдийг илүү шуурхай, цогцоор нь шийдвэрлэхийг нийгмийн сүлжээ эрхлэгчдэд даалгаж, СүлжээХХ хуулиар нийгмийн сүлжээний тохирлын дүрмүүдийг нэвтрүүлсэн болно.

Үүнд тухайн нийгмийн сүлжээ нь үзэн ядалтын гэмт хэрэг, бусад эрүүгийн хариуцлага хүлээлгэх контентэд хэрхэн хандаж байгааг тайлагнах хуулийн үүрэг, гомдлуудыг үр дүнтэй зохицуулах удирдлагын зохион байгуулалт, Герман улсад оршин суух гомдол хүлээн авагчийг томилох заалтууд багтана. Энэхүү үүргүүдийг зөрчсөн тохиолдолд аж ахуйн нэгж, хяналт тавих үүрэгтэй албан тушаалтныг торгож болно. Үүнээс гадна нийгмийн сүлжээнд хүний эрхийг зөрчсний улмаас хохирсон иргэдэд шүүхийн шийдвэрийг үндэслэн эрх зөрчигчдийн бүртгэлийн мэдээллийг сүлжээ эрхлэгчээс авах боломж олгосон юм.

2 Үндсэн агуулга

1. Гомдлыг үр дүнтэй хянан шийдвэрлэх ажиллагаа

СүлжээХХ хууль нь гомдлыг үр дүнтэй, ил тод шийдвэрлэх зохицуулалтын заавал мөрдөх ёстой стандартуудыг тогтоож өгсөн. Томоохон сүлжээ эрхлэгчид гэмт хэргийн шинжтэй контентийн тухай гомдлыг дамжуулах зорилготой, хялбар танигдах, шууд нэвтрэх боломжтой болон байнгын ажиллагаатай сүлжээг хэрэглэгчдэд санал болгоно. Сүлжээн дэх гомдлыг шуурхай бүртгэж гэмт хэргийн шинж чанартай эсэхийг шалгах, илт гэмт хэргийн шинж чанартай контентийг гомдол ирснээс хойш 24 цагийн дотор устгах эсвэл блоклох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх контентийг зарчмын хувьд гомдол ирснээс хойш 7 хоногийн дотор устгах эсвэл блоклох, эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн өөрөө зохицуулах байгууллагад шилжүүлэх ба түүний шийдвэрийг дагах, хэрэглэгчдэд тэдний гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн болон шийдвэрийн үндэслэлийн тухай мэдээлэхийг даалгасан болно.

2. Тайлагнах үүрэг

Томоохон нийгмийн сүлжээ эрхлэгч нь хагас жил тутам эрүүгийн гэмт хэргийн шинжтэй контенттэй холбоотой гомдлуудыг хэрхэн зохицуулсан тухай тайлан гаргах үүрэгтэй. Тухайн тайланд гомдлуудын тоо хэмжээ, тэдгээрийг нийгмийн сүлжээ өөрөө хэрхэн

шийдвэрлэсэн, гомдлуудыг шийдвэрлэх чиг үүрэгтэй байгууллагын нэгжүүдийн хүний нөөц, эрх мэдлийн тухай мэдээлэл зэргийг тусгасан байна. Тайланг хүн бүрт хүртээмжтэй байдлаар интернетэд нийтэлнэ.

3. Мөнгөн торгууль

Нийгмийн сүлжээ эрхлэгч нь гомдлуудыг зохицуулах тогтолцоог огт бий болгоогүй эсвэл учир дутагдалтай зохион байгуулсан бол хэв журмыг зөрчсөнд тооцно. Зөрчил гарсан бол гомдлуудыг зохицуулах ажиллагааг хариуцсан хүнд таван сая евро хүртэлх мөнгөн торгуулийг ногдуулж болно. Тухайн аж ахуйн нэгжийг 50 сая хүртэл еврогоор торгож болно. Нийгмийн сүлжээ эрхлэгч тайлагнах үүргээ огт эсвэл хангалтгүй хэрэгжүүлэх тохиолдолд мөн мөнгөн торгууль ногдуулж болно.

4. Итгэмжлэгдсэн хүлээн авагч

Мөнгөн торгууль ногдуулах болон иргэний хэргийн шүүхийн ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг илүү сайн хангах үүднээс нийгмийн сүлжээ эрхлэгчийн албан ёсны хаягаас үл хамааран Герман улсад оршин суух, бичиг баримтуудыг хүлээн авах итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох, түүнийг өөрийн платформ дээр нийтэд мэдээлэх үүрэгтэй. Мөн Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх албаны мэдээлэл өгөх хүсэлтүүдийг хүлээн авах эрх бүхий төлөөлөгчийг Герман улсад томилсон байвал зохино. Түүнчлэн нийгмийн сүлжээ эрхлэгч энэхүү хүсэлтүүдэд шуурхай хариу өгөх нөхцлүүдийг хангасан байна. Итгэмжлэгдсэн баримт хүлээн авагч, эрх бүхий төлөөлөгчийг томилох үүргийг зөрчсөн бол мөн торгуулийн арга хэмжээ авч болно.

5. Нийгмийн сүлжээ эрхлэгчээс мэдээлэл шаардах эрх

Тус хуулийн үйлчлэх нутаг дэвсгэрт хувь хүний эрхээ зөрчүүлсэн хүн бүр зарчмын хувьд энэхүү эрхийн зөрчлийг үйлдсэн этгээдийн тухай мэдээлэл өгөхийг нийгмийн сүлжээ эрхлэгчээс шаардаж болно. Мэдээлэл шаардах энэхүү эрх нэгэнт Иргэний хуулийн зарчмуудад тусгагдсан билээ. СүлжээХХ хуулиар энэхүү мэдээлэл шаардах эрхийг хэрэгжүүлэх зохицуулалтуудыг тогтоож өгсөн. Сүлжээ эрхлэгч нь улмаар хувийн нууц хадгалах тухай хууль тогтоомжийн дагуу нууцлах ёстой эрх зөрчигчийн бүртгэлийн мэдээллийг эрх зөрчигдсэн хүнд дамжуулах эрх зүйн үндэслэлтэй болсон. Тийм хэдий ч нийгмийн сүлжээний мэдээллийг гаргаж өгөхөд Иргэний хэргийн шүүгчийн тогтоол шаардлагатай (шүүгчийн шийдвэрээс хамаарна).

3 Хуулийн шинэчилсэн найруулга

Сүлжээ ХХ хууль нь хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 2 хууль тогтоох ажиллагааны объект болж ирсэн.

1. Хэт барууны үзэл ба үзэн ядалтын гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль

Нийгмийн сүлжээнд эрүүгийн хариуцлагыг чангатгах зорилгоор 2021 оны 4-р сарын 3-нд баталсан Хэт барууны үзэл ба үзэн ядалтын гэмт хэрэгтэй тэмцэх хуулийн дагуу СүлжээХХ хуулинд гэмт хэргийг мэдэгдэх үүргийг нэмж оруулсан. Үүний дагуу нийгмийн сүлжээ эрхлэгч тодорхой ноцтой хүнд гэмт хэргийг Холбооны улсын Эрүүгийн цагдаагийн газрын (ЭЦГ) төвд мэдэгдэх үүрэгтэй. Сүлжээ эрхлэгч нь нийтлэлийн агуулга болон контент үйлдвэрлэгчийн мэдэгдэж буй датаг (сүүлийн Log-In IP дугаарын хамт) ЭЦГ-т дамжуулан

өгнө. Тэрбээр цаг алдалгүй гэмт хэрэгтнийг тогтоож, холбогдох хууль сахиулах байгууллагуудад шилжүүлнэ. 2022 оны 3-р сарын 1-ний өдрийн Кёльн хотын Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн улмаас мэдэгдэх үүргийг хараахан хэрэгжүүлээгүй байна.

2. Сүлжээнд хуулийг хэрэгжүүлэх тухай хуулинд өөрчлөлт оруулах тухай хууль (СүлжээXXXӨ)

СүлжээXXXӨ тухай хууль 2021 оны 6-р сарын 28-нд хүчин төгөлдөр болсноор нийгмийн сүлжээний хэрэглэгчдийн эрхийг илүү баталгаажуулсан. Тэд зарим контентийг устгах эсвэл үлдээх асуудлаар өөр бодолтой байвал сүлжээ эрхлэгчдийн шийдвэрүүдийг илүү үр дүнтэй эсэргүүцэх боломжтой болсон. Үүний зэрэгцээ гутаан доромжлол, гүтгэлэг зэрэг эрүүгийн шинжтэй үйлдэлд өртсөн хүмүүсийн мэдээлэл шаардах эрхийг илүү хялбар хэрэгжүүлэх бололцоо олгосон. Эцэст нь мэдээлэх үүргүүдийг тодорхой болгож, сүлжээний үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх юм. Энэ зорилгоор тайланд жишээ нь өмнөх тайлангаас хойш бий болсон өөрчлөлтүүдийг зааж өгнө.

Үүнээс гадна Европын холбооны Аудио хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн тухай (AVMD-RL) 2010/13/EU тоот зааварт нэмэлт оруулж, шинэ (EU) 2018/1808 тоот зааврын заалтуудад СүлжээXX-г СүлжээXXӨ-ийн хамт нийцүүлэн өөрчилсөн. AVMD-RL нь видео түгээх платформуудаар үл зөвшөөрөгдөх контентийг дамжуулахаас сэргийлэх тохирлын заалтуудыг дотроо агуулна. Энэхүү платформуудын үйл ажиллагаа СүлжээXX хуулиар хэсэгчлэн зохицуулагдаж байсан. Өмнөх СүлжээXXX-с ялгаатай нь AVMD-RL тохирлын шаардлагауудыг мөн жижиг, явцуу хүрээний видео түгээлтийн платформуудад тавих болсон явдал юм.

4 Сүлжээ XX хуульд оруулсан голлох шинэчлэлүүдийг тус бүр дурдвал:

а. Хэрэглэгчдийн эрх ашгийг илүү баталгаажуулсан

Нийгмийн сүлжээний хэрэглэгчдийн эрх ашгийн хамгаалалтыг дараах арга хэмжээгээр сайжруулсан:

аа. Дахин шалгалтын ажиллагааг нэвтрүүлсэн (СүлжээXX хуулийн 3б зүйл)

Аль нэг нийгмийн сүлжээний хэрэглэгч болон эрхлэгчийн хооронд контентийг устгах талаар санал зөрөлдсөн тохиолдолд дахин шалгалтын ажиллагаа явуулж болно. Үүний үр дүнд нийгмийн сүлжээ эрхлэгч хэрэглэгчийн өргөдлийн дагуу контентийг устгах эсвэл үлдээх тухай өөрийн шийдвэрээ дахин шалгах үүрэгтэй. Шалгалтын үр дүнг тус бүр хэрэглэгчид үндэслэлийг нь тайлбарлан мэдэгдэнэ.

Тодруулбал: Хэрэглэгчийн нийтэлсэн контентийг нийгмийн сүлжээ устгасан бол тэрбээр энэхүү шийдвэрийг эргэн харахыг сүлжээ эрхлэгчээс шаардаж болно. Эсрэгээрээ аль нэг контентийг хууль бус гэж мэдэгдсэн хүн сүлжээ эрхлэгч контентийг устгаагүй бол энэ шийдвэрийг дахин шалгахыг шаардах эрхтэй. Дахин шалгах ажиллагааг мөн СүлжээXX хуулийн дагуу гомдол гараагүй байсан ч контентийг устгасан тохиолдолд мөн явуулж болно.

bb. Гомдол хүлээн авагчийн хариуцах ажлыг тодруулсан (Сүлжээ ХХХ-ийн 5-р зүйлийн 1-р хэсэг)

Нийгмийн сүлжээ өмнөх СүлжээХХ хуулийн дагуу ч Германы шүүхээр шийдвэрлэгдэх хууль бус контентийг түгээсэн хэргийн материалыг хүлээн авах хүнийг томилох үүрэг хүлээсэн байв. Практик дээр энэхүү томилогдсон материал хүлээн авагч мөн нийгмийн сүлжээнээс устгасан контентийг сэргээх тухай гомдлуудыг хариуцах эсэхээр талууд өөр өөр ойлголттой байсан. Сэргээх гомдол гаргасан контент зохиогч нь нийгмийн сүлжээнээс устгасан өөрийн контентийг дахин сүлжээгээр түгээхийг шаардаж, түүний аккаунтыг зүй бусаар устгасан эсвэл блокловсон хэмээн нийгмийн сүлжээг буруутгадаг.

СүлжээХХӨ хуулиар сэргээх тухай гомдлуудын материалыг ч итгэмжлэгдсэн хүлээн авагч гардан авахыг зааж өгсөн. Улмаар нийгмийн сүлжээнээс хууль бус контент түгээсэн гэх үндэслэлээр зүй бусаар аккаунтыг устгах, блоклохоос хамгаалах ажил сайжирна.

cc. Хараат бус эвлэрүүлэн зуучлагчийг бий болгох үндэс суурийг тавьсан (Сүлжээ ХХХ-ийн 3-р зүйл)

Хувийн эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаатайгаар хэрэглэгч болон нийгмийн сүлжээ эрхлэгч хоорондын маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх боломжтой. Улмаар ихэнхи тохиолдолд оролцогч талууд илүү хурдан, зардал багатайгаар маргааныг зохицуулах бололцоотой болдог. Энэхүү эвлэрүүлэн зуучлагчийг хүлээн зөвшөөрөх нөхцлүүдийг хуулиар зохицуулдаг. Германд байрлах видео түгээх платформуудын хувьд захиргааны шүүхийн хуралдааны өмнөх эвлэрүүлэн зуучлагчийг бий болгосон.

b. Лавлагаа авах эрхийг илүү хялбар хэрэгжүүлэх болсон:

Нийгмийн сүлжээн дэх эрүүгийн хариуцлага хүлээлгэх айлган сүрдүүлэх эсвэл гутаан доромжлох контент нь ихэнх тохиолдолд хувь хүмүүсийн эрхийг зөрчдөг. Үүнд өртөгсөд Мэдээлэл, өргөн нэвтрүүлгийн хэвлэлийн хэрэгсэл, мэдээллийн нүүц хадгалах тухай хуулийн (МӨНХХМНХ) 21-зүйлийн дагуу нийгмийн сүлжээ эрхлэгчээс өөрийн эрхээ хамгаалах, хэрэгжүүлэхэд хэрэгтэй мэдээллийг, жишээ нь нийтлэгчийн нэрийг өгөхийг шаардаж болно.

Лавлагаа өгөх зөвшөөрлийг шүүхээр урьдчилан шийдвэрлүүлнэ. Практик дээр үйлчилгээ үзүүлэгчид олон тохиолдолд энэхүү шийдвэр гарсан ч шүүхээс зөвхөн лавлагаа өгөх зөвшөөрөл олгосон, үүрэг ногдуулаагүй гэх шалтгаанаар мэдээлэл өгөхөөс татгалздаг. Холбогдох хүн дахин шүүхэд хандаж, үйлчилгээ үзүүлэгчид мэдээлэл өгөх үүргийг баталгаажуулах хэрэгтэй болдог.

Энэ нь олон тохиолдолд нилээд төвөгтэй ба удаан үргэлжилдэг. СүлжээХХӨ хуулиар мэдээлэл өгөх зөвшөөрлийн асуудлыг хянан шийдвэрлэх шүүх нэгэн зэрэг мөн мэдээлэл өгөх үүргийг тогтоох боломжтой тул лавлагаа авах эрхийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх болсон.

c. Мэдүүлэг өгөх ажиллагааг хэрэглэгчдэд илүү хялбаршуулж сайжруулсан (Сүлжээ ХХХ-ийн 3-р зүйлийн 1-р хэсэг)

Нийгмийн сүлжээнд хууль бус контентийг мэдүүлэх арга хялбар байх ёстой. Практик дээр нийгмийн сүлжээнд хууль бус контентийг мэдэгдэх арга замыг зарим үед хэрэглэгчдэд

төвөг ихтэй байдлаар зохион байгуулж ирсэн. Олоход хэцүү, олон удаа товшиж үрт замыг туулж (жишээ нь контентийн холбоос зэрэг нотлох баримтуудыг гараар хуулбарлах, оруулах) хууль бус контентийн тухай мэдээлэх явцыг шинэ СүлжээХХ хуулиар хүлээн зөвшөөрөхгүй. Тиймээс СүлжээХХ хуулийн шинэчилсэн найруулгаар мэдээлэх арга замыг хялбархан олох, хүн бүрт ашиглахад төвөггүй байхыг маш тодорхой зааж өгсөн ба бүр хууль бус гэж мэдээлэх контентээс шууд дамжуулан мэдэгдэх боломж байх ёстой.

d. Ил тод байдлын тайлангийн мэдээллийн агуулгыг нэмэгдүүлсэн (СүлжээХХХ-ийн 2-р зүйлийн 2-р хэсэг)

Нийгмийн сүлжээ эрхлэгчдийн ил тод байдлын тайлан нь тэдний тайлагнах үүргийн чухал нэгэн хэрэгсэл юм. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл нийгмийн сүлжээ эрхлэгчдийн гаргасан тайлангууд мэдээллийн агууламж, бусадтай харьцуулах боломжийн хувьд учир дутагдалтай байв. Ирээдүйд тайланд өмнөх сүүлийн хоёр тайлангаас хойш гарсан өөрчлөлтүүдийг тодорхой тайлбарлах шаардлагатай. Үүнээс гадна нийгмийн платформууд нь дахин шалгалтын ажиллагааг хэрхэн хэрэгжүүлсэн (жишээ нь устгасан контентийг сэргээсэн „Put backs“ гэх тохиолдолдын тоог мэдээлнэ). Үүнээс гадна хууль бус байж болзошгүй контентийг олж илрүүлэх автоматжуулсан хэрэглээний програмуудын ерөнхий тойм танилцуулгыг хүргүүлэх ёстой.

e. Эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх боломжийг сайжруулсан (Сүлжээ ХХХ-ийн 5а зүйл)

Нийгмийн сүлжээнд явагдах мэдээлэл солилцоо, харилцаа холбоо нь өнөө үед нийтийн санал бодолд ихээхэн ач холбогдолтой болсон билээ. Тиймээс нийгмийн сүлжээн дэх (хууль бус) контент түгээлт болон хэсэгчлэн автоматжуулсан мэдээ мэдээлэл дамжуулах механизмуудыг судлах үйл явцад олон нийт ихээхэн анхаарал хандуулдаг. Хуулинд тусгасан тусгай эрдэм шинжилгээний заалтаар эрдэм шинжилгээний байгууллага, шинжээчдэд устгах ёстой контентийг автоматаар олж танихад шаардлагатай дата мэдээг авах боломжийг олгосон. Мөн хэрэглэгчдийн гомдлын сэдэв болж байсан, эсвэл сүлжээ эрхлэгчийн зүгээс устгасан контентийг түгээж байсан эсвэл түүнээс байгаа тухай мэдээллийг шинжээчид авах бололцоотой. Судалгааны явцад зүй бусаар байгууллагын нууц, бусад оролцогч талуудын эрх ашгийг зөрчихгүйн үүднээс судлаачид шаардлага хангасан хамгаалалтын хөтөлбөр боловсруулж, танилцуулах үүрэгтэй.

2022 оны 12-р сарын 21-ний байдлаар

Нийгмийн сүлжээнд
хуулийн хэрэгжүүлэлтийг сайжруулах тухай хууль
(Сүлжээнд хууль хэрэгжүүлэх тухай хууль—СүлжээXXX)
2017 оны 9-р сарын 1

Бундестаг дараах хуулийг соёрхон баталсан болно:

1-р бүлэг

**Нийгмийн сүлжээнд хуулийн хэрэгжүүлэлтийг сайжруулах тухай хууль
(Сүлжээнд хууль хэрэгжүүлэх тухай хууль—СүлжээXXX))**

1-р зүйл

Хуулийн үйлчлэх хүрээ

- (1) Энэ хууль интернет дэх платформуудыг ашиг олох зорилгоор ажиллуулж, хэрэглэгчдэд дурын контентийг бусад хэрэглэгчтэй хуваалцах эсвэл олон нийтэд түгээх (нийгмийн сүлжээ) харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчдэд үйлчилнэ. Сэтгүүл зүй-редакцийн зохицуулалттай, үйлчилгээ үзүүлэгч өөрөө хариуцах платформуудыг энэ хуулийн утгаар нийгмийн сүлжээ гэж үзэхгүй. Энэ нь мөн хувь хүмүүсийн харилцаа холбоо эсвэл тусгай агуулгын мэдээлэл солилцоонд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- (2) Тухайн нийгмийн сүлжээ тус улсад хоёр саяаас бага бүртэгдсэн хэрэглэгчтэй тохиолдолд нийгмийн сүлжээ эрхлэгчийг 2 ба 3-р зүйлийн дагуу ногдуулах үүргээс чөлөөлнө.
- (3) Хууль бус контент гэж 1-р хэсгийн утгаар Эрүүгийн хуулийн 86, 86а, 89а,91, 100а, 111, 126, 129 bis 129b, 130, 131, 140, 166, 184b мөн 184d, 185 bis 187, 201а, 241 эсвэл 269-р зүйлийн дагуу хэргийн бүрэлдэхүүнийг хангасан ба үндэслэлгүй контентийг ойлгоно.

2-р зүйл

Тайлагнах үүрэг

- (1) Хуанлийн жилд хууль бус контентийн тухай 100-аас илүү гомдол хүлээн авсан нийгмийн сүлжээ эрхлэгч өөрийн платформ дээрх хууль бус контентийн тухай гомдлуудыг хэрхэн зохицуулсан тухай 2-р хэсгийн дагуу хагас жил бүр герман хэл дээр тайлан гаргаж, Холбооны улсын Төрийн мэдээллийн эмхтгэлд болон өөрийн Noмерpage дээр хагас жил дууссанаас хойш нэг сарын дотор олон нийтэд мэдээлнэ.
- (2) Тайланд хамгийн багадаа дараахи асуудлуудыг танилцуулна:
 1. Нийгмийн сүлжээ эрхлэгч өөрийн платформ дээрх эрүүгийн хариуцлага хүлээлгэх контенттэй хэрхэн тэмцэж байгаа тухай ерөнхий танилцуулга,

2. Хууль бус контентийн тухай гомдлуудыг дамжуулах механизмууд, хууль бус контентийг устгах, блоклох тухай шийдвэр гаргах шалгууруудын тайлбар,
3. Тайлант хугацаанд ирүүлсэн гомдлуудын тоо, гомдол мэдүүлэгч (хэрэглэгч, хянан шалгах байгууллага) болон гомдлын шалтгаан тус бүрээр ангилсан хэлбэрээр,
4. Гомдлуудыг боловсруулах үүрэгтэй ажлын хэсгүүдийн зохион байгуулалт, мэргэжлийн болон хэлзүйн чадамж болон гомдлуудыг зохицуулах үүрэгтэй ажилтнуудын сургалт, тэдэнд үзүүлэх дэмжлэг,
5. Мэргэжлийн холбоодын гишүүнчлэл ба энэ холбоодод гомдол хүлээн авах нэгжтэй эсэхийг заана,
6. Хөндлөнгийн байгууллагын зөвлөгөө авч шийдвэрлэсэн гомдлуудын тоо,
7. Тайлант хугацаанд гомдол дагуулсан контентийг устгасан тохиолдлын тоо, гомдол мэдүүлэгч (хянан шийдвэрлэх байгууллага, хэрэглэгч) болон гомдлын шалтгаан тус бүрээр ангилсан хэлбэрээр, мөн 3-р зүйлийн 2-р хэсгийн 3а дугаарт заасан тохиолдол илэрсэн, үүнийг хэрэглэгчдэд дамжуулсан болон 3-р зүйлийн 2-р хэсгийн 3б дугаарын дагуу хүлээн зөвшөөрөгдсөн өөрөө зохицуулах байгууллагад шилжүүлсэн эсэх,
8. Нийгмийн сүлжээнд ирүүлсэн гомдол болон хууль бус контентийг устгах эсвэл блоклох хоорондын цаг хугацаа, гомдол мэдүүлэгч (хянан шийдвэрлэх байгууллага, хэрэглэгч) болон гомдлын шалтгаан тус бүрээр ангилсан хэлбэрээр, „24 цагийн дотор“/„48 цагийн дотор“/„7 хоногийн дотор“/„өөр хожмын цагт“ гэх цаг хугацааны үзүүлэлтээр,
9. Гомдол гаргагч болон гомдол дагуулсан контентийг хадгалсан хэрэглэгчид гомдлын шийдвэрийн тухай мэдээлэл хүргүүлэх арга хэмжээ.

3-р зүйл

Хууль бус контентийн тухай гомдлыг зохицуулах

- (1) Нийгмийн сүлжээ эрхлэгч нь 2 ба 3-р хэсгийн дагуу хууль бус контентийг зохицуулах үр дүнтэй, ил тод үйл ажиллагааны журамтай байна. Үйлчилгээ үзүүлэгч хэрэглэгчдэд амархан танигдах, шууд нэвтрэх боломжтой болон байнгын ажиллагаатай механизмыг хууль бус контентийн тухай гомдлыг дамжуулах зорилгоор санал богино.
- (2) Механизм нь нийгмийн сүлжээ эрхлэгчийг дараах боломжоор хангасан байна:
 1. Гомдлын тухай шуурхай мэдээлэл авах, гомдолд мэдүүлсэн контент нь хууль бус болох ба устгах, эсвэл түүнийг блоклох эсэхийг шийднэ,
 2. Илт хууль бус контентийг 24 цагийн дотор устгах эсвэл блоклох; нийгмийн сүлжээ холбогдох эрүүгийн хууль сахиулах байгууллагатай илт хууль бус контентийг устгах эсвэл блоклох илүү урт хугацааг тохирсон бол энэ заалт үйлчлэхгүй,
 3. Хууль бус контентийг цаг алдалгүй, ерөнхийдөө гомдол ирүүлснээс хойш долоон хоногийн дотор устгах эсвэл блоклох; долоо хоногийн хугацааг дараах нөхцөлд

хэтрүүлж болно:

- a) Контентийн хууль бус байдлын тухай шийдвэр нь бодит мэдүүлэг эсвэл бусад бодит, илт нөхцөл байдлаас хамаарах бол; энэ тохиолдолд нийгмийн сүлжээ шийдвэр гарахаас өмнө хэрэглэгчид гомдлын талаар байр сууриа илэрхийлэх боломж олгож болно.
 - b) Нийгмийн сүлжээ хууль бус тухай шийдвэрийг гомдол ирүүлснээс хойш долоо хоногийн дотор 6-8-р хэсгийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн өөрөө зохицуулах байгууллагад шилжүүлж, түүний гаргасан шийдвэрийг дагана,
4. Устгах тохиолдолд контентийг нотлох баримт болгон баримтжуулж, энэ зорилгоор арван долоон хоногийн хугацаанд 2000/31/EG ба 2010/13/EU заавруудын үйлчлэх хүрээнд хадгална,
 5. Гомдол гаргагч болон хэрэглэгчид шийдвэр бүрийг цаг алдалгүй мэдэгдэж, өөрийн шийдвэрийг үндэслэнэ.
- (3) Ажиллагаанд гомдол бүрийг, түүнийг зохицуулахаар авсан арга хэмжээг 2000/31/EG ба 2010/13/EU заавруудын үйлчлэх хүрээнд баримтжуулна.
- (4) Гомдлуудын зохицуулалтыг нийгмийн сүлжээний удирдлага сар бүрийн хяналтаар шалгана. Ирүүлсэн гомдлуудыг зохицуулах зохион байгуулалтын дутагдлуудыг даруй засаж залруулна. Гомдлуудыг зохицуулах ажилд томилогдсон хүмүүст нийгмийн сүлжээний удирдлагын зүгээс тогтмол, хамгийн багадаа хагас жил тутамд герман хэл дээрх сургалт явуулах болон дэмжлэг үзүүлэхийг санал болгосон байна.
- (5) 1-р хэсгийн дагуу явуулах ажиллагааг 4-р зүйлд заасан захиргааны байгууллагаас томилсон этгээд хянаж болно.
- (6) Аль нэг байгууллагыг өөрөө зохицуулах байгууллага гэж дараах нөхцөлд хүлээн зөвшөөрнө:
1. Түүний шалгагч нарын хараат бус байдал, мэргэжлийн чадвар баталгаажсан,
 2. Шаардлагатай хэрэгсэл болон долоон хоногийн дотор шалгалт явуулах боломжоор найдвартай хангагдсан,
 3. Ажиллагааны журам боловсруулж шалгалтын цар хүрээ, явц болон холбогдсон нийгмийн сүлжээнүүдийн мэдүүлэх үүргүүдийг зохицуулсан, мөн шийдвэрийг эргэн харах боломжийг бүрдүүлсэн,
 4. Гомдол хүлээн авах нэгж байгуулагдсан ба
 5. Шаардлагатай хангамжийг баталгаажуулах боломжтой олон тооны нийгмийн сүлжээ эрхлэгч тус байгууллагыг санхүүжүүлдэг, түүнчлэн ялангуяа бусад нийгмийн сүлжээ эрхлэгчид элсэн ороход нээлттэй байна.
- (7) Өөрөө зохицуулах байгууллагыг хүлээн зөвшөөрөх тухай шийдвэрийг 4-р зүйлд заасан захиргааны байгууллага гаргана.
- (8) Хүлээн зөвшөөрсний дараа хүлээн зөвшөөрөх нөхцлүүд хүчингүй болсон тохиолдолд хүлээн зөвшөөрөх шийдвэрийг бүрэн эсвэл хэсэгчлэн цуцлах, эсвэл нэмэлт заалтууд ногдуулж болно.

(9) 4-р зүйлд заасан захиргааны байгууллага 2-р хэсгийн 3 дугаарын үүргүүдийг нийгмийн сүлжээ эрхлэгч өөрөө зохицуулах байгууллагыг оролцуулсан ч биелүүлэх боломжгүй гэж үзвэл 2-р хэсгийн 3b дугаарын дагуу шийдвэрийг гаргалтыг шилжүүлэхийг тодорхой хугацаанд түдгэлзүүлж болно.

4-р зүйл

Мөнгөн торгууль ногдуулах заалтууд

(1) Хэн нэгэн санаатай эсвэл санамсаргүй дараах үйлдэл хийвэл зөрчил гаргасанд тооцоно:

1. 2-р зүйлийн 1-р хэсгийн 1-р өгүүлбэрийг зөрчин тайланг гаргаагүй, бүрэн бус эсвэл тогтоосон хугацаанд гаргаагүй эсвэл заасан хэлбэрээр нийтлээгүй, алдаатай эсвэл бүрэн бус эсвэл заасан хугацаанд нийтлээгүй,
2. 3-р зүйлийн 1-р хэсгийн 1-р өгүүлбэрийг зөрчин тэнд заасны дагуу тус улсад оршин суух эсвэл амьдрах гомдол гаргагч, хэрэглэгчийн гомдлуудын зохицуулах ажиллагааг явуулаагүй, зөв эсвэл бүрэн явуулаагүй,
3. 3-р зүйлийн 1-р хэсгийн 2-р өгүүлбэрийг зөрчин тэнд заасан ажиллагааг бэлэн эсвэл зөв болгоогүй,
4. 3-р зүйлийн 4-р хэсгийн 1-р өгүүлбэрийг зөрчин гомдлуудыг зохицуулах ажиллагааг хянаагүй эсвэл зөв хянаагүй,
5. 3-р зүйлийн 4-р хэсгийн 2-р өгүүлбэрийг зөрчин зохион байгуулалтын дутагдлыг арилгаагүй, хугацаанд нь арилгаагүй,
6. 3-р зүйлийн 4-р хэсгийн 3-р өгүүлбэрийг зөрчин сургалт эсвэл дэмжлэгийг санал болгоогүй,
7. 5-р зүйлийг зөрчин дотоодын хүлээн авагч эсвэл дотоодын итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилоогүй, эсвэл
8. 5-р зүйлийн 2-р хэсгийн 2-р өгүүлбэрийг зөрчин итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд лавлагаа өгөх хүсэлтүүдэд хариу өгөөгүй.

(2) Журмын зөрчлийн 1-р хэсгийн 7 болон 8 дугаарын тохиолдолд таван зуун мянган евро хүртэлх мөнгөн торгууль, 1-р хэсгийн бусад тохиолдолд таван сая евро хүртэлх мөнгөн торгууль ногдуулж болно. Журмын зөрчлийн тухай хуулийн 30-р зүйлийн 2-р хэсгийн 3-р өгүүлбэрийг хэрэглэнэ.

(3) Журмын зөрчлийн тухай хуулийн 36-р зүйлийн 1-р хэсгийн 1 дугаарын утгаар захиргааны байгууллага нь Холбооны улсын Хууль зүйн газар болно.

(4) Холбооны улсын Хууль зүй, хэрэглэгчдийг хамгаалах яам, Холбооны улсын Дотоод хэргийн яам, Эдийн засаг, эрчим хүчний яам, Зам тээвэр, цахим дэд бүтцийн яамтай зөвшилцөн захиргааны ерөнхий зарчмуудыг тогтооно. Мөнгөн торгууль ногдуулах эрх бүхий байгууллагын торгууль ногдуулах ажиллагаа эхлүүлэх, тохирсон мөнгөн торгуулийн хэмжээг тогтоох эрх мэдлийг тодорхой зааж тогтоол батална.

(5) Захиргааны байгууллага шийдвэр гаргахдаа устгаагүй эсвэл блоклоогүй контентийг 1-р зүйлийн 3-р хэсгийн утгаар хууль бус гэж үзвэл хууль бус болох тухай шүүхийн шийдвэрийг урьдчилан гаргуулсан байвал зохино. Энэ асуудал мөнгөн торгуулийн эсрэг мэдүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх шүүхэд харьяалагдана. Урьдчилан шүүхийн шийдвэр гаргуулах өргөдлийг нийгмийн сүлжээний байр сүүрийг илэрхийлсэн баримтын хамт шүүхэд хүргүүлнэ. Өргөдлийг аман хэлэлцүүлэггүйгээр шийдвэрлэж болно. Шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхгүй ба захиргааны байгууллагын хувьд эцсийнх байна.

5-р зүйл

Дотоодын баримт хүлээн авагч

(1) Нийгмийн сүлжээ дотоодын баримт хүлээн авагчийг томилох үүрэгтэй ба өөрийн платформ дээр түүнийг амархан танигдах, шууд холбогдох байдлаар танилцуулна. Энэ хүнд 4-р зүйлийн дагуу хууль бус контентийг түгээсний улмаас явагдах ажиллагаа эсвэл Герман улсын шүүхийн ажиллагааны баримтуудыг хүргүүлж болно. Энэ заалт мөн энэхүү ажиллагааг эхлүүлэх бичиг баримтанд хамаарна.

(2) Эрүүгийн хууль сахиулах дотоодын байгууллагаас ирсэн лавлагаа гаргаж өгөх тухай хүсэлтүүдийг гардан авахаар итгэмжлэгдсэн дотоодын төлөөлөгчийг томилно. Гардан хүлээн авахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч 1-р өгүүлбэрийн дагуу лавлагаа гаргаж өгөх хүсэлтүүдэд 48 цагийн дотор хариулах үүрэгтэй. Хүссэн лавлагааг бүрэн хэмжээнд өгөөгүй тохиолдолд үүнийг хариунд тайлбарлана.

6-р зүйл

Шилжилтийн заалт

(1) 2-р зүйлд заасан тайланг 2018 оны эхний хагаст гаргаж эхэлнэ.

(2) 3-р зүйлд заасан ажиллагааг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш гурван сарын дотор нэвтрүүлсэн байна. 1-р зүйлийн нөхцлүүдийг нийгмийн сүлжээ эрхлэгч хожимдуулан биелүүлэх бол 3-р зүйлд заасан ажиллагааг энэ цаг хугацаанаас хойш гурван сарын дотор нэвтрүүлсэн байна.

2-р бүлэг

Өргөн нэвтрүүлгийн харилцаа холбооны тухай хуулийн өөрчлөлт

2007 оны 2-р сарын 26-нд баталсан (BGBl. IS. 179, 251), хамгийн сүүлд 2016 оны 7 сарын 1-нд баталсан хуулийн 1-р зүйлээр өөрчлөлт орсон (BGBl. I S. 1766)

Өргөн нэвтрүүлгийн харилцаа холбооны тухай хуулийг дараах байдлаар өөрчилсүгэй:

1. 14-р зүйлд дараах 3-5 хэсгүүдийг нэмсүгэй:

„(3) Үүнээс гадна онцгой тохиолдолд “Сүлжээнд хуулийн хэрэгжүүлэлтийг сайжруулах” тухай хуулийн 1-р зүйлийн 3-р хэсэгт тусгасан хууль бус контент түгээж онцгой

хамгаалагдсан эрхийг зөрчсөнийг эсэргүүцэж гаргасан эрх сэргээх шаардлагыг хангахад шаардлагатай бол үйлчилгээ үзүүлэгч өөрт байгаа бүртгэлийн мэдээллийн лавлагаа өгч болно.

(4) 3-р хэсгийн дагуу лавлагаа өгөхийг зөвшөөрсөн шүүхийн урьдчилсан шийдвэр шаардлагатай ба үүний тулд эрх нь зөрчигдсөн этгээд өргөдөл гаргана. Энэхүү шийдвэрийг маргааны зүйлийн үнэ цэнээс үл хамааран холбогдох муж улсын шүүх гаргана. Нутаг дэвсгэрийн хувьд эрх нь зөрчигдсөн хүний амьдрах, оршин суух эсвэл салбар нээсэн дүүргийн шүүхэд харъяалагдана. Шийдвэрийг шүүхийн иргэний хэргийн танхим гаргана. Ажиллагаанд “Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийг чөлөөтэй сонгох” тухай хуулийн заалтууд зохих ёсоор үйлчилнэ. Шүүхийн зардлуудыг эрх нь зөрчигдсөн этгээд хариуцна. Муж улсын шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болно.

(5) 4-р зүйлийн дагуу ажиллагаанд үйлчилгээ үзүүлэгчийг холбогдогчоор татан оролцуулна. ТЭрбээр хэрэглэгчид ажиллагаа эхэлсний тухай мэдэгдэж болно.”

2. 15-р зүйлийн 5-р хэсгийн 4-р өгүүлбэрийг дараах байдлаар найруулна:
„14-р зүйлийн 2-5 хэсгүүдийг зохих ёсоор хэрэглэнэ.“

3-р бүлэг Хүчин төгөлдөр болох

Энэ хууль 2017 оны 10-р сарын 1-нд хүчин төгөлдөр болно.

Холбооны улсын Зөвлөлийн Үндсэн хуульд заасан эрхүүдийг хангасан болно.
Үүгээр тус хуулийг албажуулсан болно. Түүнийг Холбооны улсын хуульн эмхэтгэлд зарлан нийтлэнэ.

Берлин хот, 2017 оны 9-р сарын 1

Холбооны улсын Ерөнхийлөгч Штайнмайер

Холбооны улсын Канцлер

Др. Ангела Меркель

Холбооны улсын Хууль зүй, хэрэглэгчдийг хамгаалах яамны Сайд

Хайко Маас